

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СУДАЛГАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨВ  
ТӨААТҮГ-ЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитын код: СНАГ-2024/107/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	<b>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг</b> Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn <b>Аудитын менежер: Ч.Болд</b> Утас: 260512 Цахим хаяг: boldch@audit.gov.mn <b>Ахлах аудитор: И.Эрдэнэцэцэг</b> Утас: 261628 Цахим хаяг: erdenetsetsegi@audit.gov.mn <b>“Амгалан Ахуй Аудит” ХХК-ийн захирал: Д.Амгалан</b> Утас: 88054499 Цахим хаяг: amgalanahui.audit@gmail.com
---	--

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.03.15 № 07/749  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН  
СУДАЛГАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ  
ТӨВ ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Ж.ЧОЙНХАНД ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 950.7 сая төгрөгөөр өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 зүйлийн 15.2.5-д заасантай тус тус нийцээгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгаль орчин судалгаа шинжилгээний төв УТҮГ-тай хамтран орон нутагт уул уурхайгаас үүдэлтэй хөрсний бохирдлын түүвэрчилсэн судалгааг гүйцэтгэх байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, байгаль хамгаалагчдыг чадавхжуулах сургалтыг 21 аймагт зохион байгуулсан байна.

### Аудитын гол асуудал

Тайлант онд орлогыг 1,723.4 сая төгрөг, зардлыг 1,716.6 сая төгрөг, цэвэр ашгийг 6.1 сая төгрөг байхаар баталж, гүйцэтгэлээр 2,696.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,607.0 сая төгрөгийн зардал гарган, 80.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Z:\Yawsan\_Bichig\2024\0315 SNAG-49.Docx

0001051576

### **Бусад асуудлын хэсэг**

Тус газар нь “Үндэсний дөрөвдүгээр тайлан илтгэл, хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн нэмэлт хоёрдугаар тайлан илтгэл боловсруулах арга хэмжээг хэрэгжүүлэх төсөл”, “хамтарсан кредит олгох механизмын нарийн бичгийн газар”-ын үйл ажиллагаа, чиг үүргийн хүрээнд бий болгосон дэд төслүүдийг оролцуулан 1.364.5 нийт сая төгрөгийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,548,023,156.97	424,355,401.62
1.1.02	Дансны авлага	0.00	53,990,100.00
1.1.04	Бусад авлага	21,004,490.00	17,356,581.00
1.1.06	Бараа материал	58,123,229.91	55,067,619.00
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	131,635,992.00	30,000,000.00
1.1.09	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	0.00	75,997,800.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,758,786,868.88	656,767,501.62
1.2.01	Үндсэн хөрөнгө	100,484,934.64	78,055,982.96
1.2.02	Биет бус хөрөнгө	1,312,500.00	1,823,682.47
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	101,797,434.64	79,879,665.43
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,860,584,303.52	736,647,167.05
2.1.1.01	Дансны өглөг	0.00	13,195,100.00
2.1.1.02	Цалингийн өглөг	13,000.12	26,567,414.00
2.1.1.03	Татварын өр	1,039,640.86	12,551,431.53
2.1.1.04	НДШ - ийн өглөг	0.00	11,124,818.00
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	1,632,264,243.00	361,356,819.99
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,633,316,883.98	424,795,583.52
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,633,316,883.98	424,795,583.52
2.3.09	Хуримтлагдсан ашиг	227,267,419.54	311,851,583.53
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	80,564,658.99
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	227,267,419.54	231,286,924.54
2.3.11	Эздийн өмчийн дүн	227,267,419.54	311,851,583.53
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,860,584,303.52	736,647,167.05

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,847,146,954.00	1,863,115,318.66
2	Борлуулалтын өртөг	0.00	1,627,768,693.66
3	Нийт ашиг( алдагдал)	1,847,146,954.00	235,346,625.00
5	Хүүгийн орлого	0.00	7,930,294.40
8	Бусад орлого	100,291,800.00	825,495,794.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,938,193,532.96	979,246,511.18
12.1	Зардлын дүн	1,938,193,532.96	979,246,511.18
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	-9,914.46
17.1	Олз, гарзын дүн	0.00	-9,914.46
18	Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)	9,245,221.04	89,516,287.76
19	Орлогын татварын зардал	924,522.10	8,951,628.77
20	Татварын дараах ашиг (алдагдал)	8,320,698.94	80,564,658.99
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	8,320,698.94	80,564,658.99

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	-	-	221,296,720.60	221,296,720.60
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	8,320,698.94	8,320,698.94
7	Зарласан ногдол ашиг	-	-	2,350,000.00	2,350,000.00
9	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	-	-	227,267,419.54	227,267,419.54
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	8,179,855.00	8,179,855.00
11	Залруулсан үлдэгдэл	-	-	235,447,274.54	235,447,274.54
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	80,564,658.99	80,564,658.99
15	Зарласан ногдол ашиг	-	-	4,160,350.00	4,160,350.00
17	2023 оны 12 сарын 31-р үлдэгдэл	-	-	311,851,583.53	311,851,583.53

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,392,642,066.00	1,600,341,232.05
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,319,167,716.00	537,688,860.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	73,474,350.00	1,062,652,372.05
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,136,280,047.47	2,727,908,331.18
1.2.1	Ажиллагчдад төлсөн	449,400,534.66	491,232,980.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	130,023,269.21	127,199,443.17
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	6,091,000.00	4,069,900.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	63,598,989.30	94,086,955.84
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,800,000.00	300,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	49,818,322.93	54,427,708.61
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,433,547,931.37	1,956,591,343.56
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-743,637,981.47	-1,127,567,099.13
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	7,869,258.24
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	0.00	7,869,258.24
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	8,564,900.00	3,960,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-8,564,900.00	3,960,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	3,909,258.24
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	326,511.23
3.1.4	Бусад	0.00	326,511.23
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	336,425.69
3.2.5	Бусад	0.00	336,425.69
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	-9,914.46
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-752,202,881.47	-1,123,667,755.35
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,300,226,038.44	1,548,023,156.97
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,548,023,156.97	424,355,401.62

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлтүүд	2023 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	(зөрүү)	(хувь)
1	Үндэсний дөрөвдүгээр тайлан илтгэл, хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн нэмэлт хоёрдугаар тайлан илтгэл боловсруулах арга хэмжээг хэрэгжүүлэх төсөл /NC4 BUR2/	91,014.0	500,913.7	(409,899.7)	550.4
	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бэхжүүлэх төсөл /NAP/	987,000.0	1,074,002.2	(87,002.1)	108.8
	ХКОМ-ын нарийн бичгийн газрын санхүүжилт	58,000.0	52,852.9	5,147.1	91.1
	Чиг үүргийн хүрээнд авч хэрэгжүүлэх дэд төслүүд	587,400.0	1,068,772.7	(481,372.7)	181.9
<b>2</b>	<b>Нийт орлого</b>	<b>1,723,414.0</b>	<b>2,696,541.4</b>	<b>(973,127.4)</b>	<b>156.5</b>
<b>3</b>	<b>Нийт зардал</b>	<b>1,716,609.1</b>	<b>2,607,015.2</b>	<b>(890,406.1)</b>	<b>151.9</b>
3.1	Үүнээс: Удирдлагын зардал	70,499.3	94,500.0	(24,000.7)	134.0
<b>3.2</b>	<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>1,716,609.1</b>	<b>2,607,015.2</b>	<b>(890,406.1)</b>	<b>151.9</b>
3.2.1	Үндсэн ба нэмэгдэл цалингийн зардал	500,324.1	643,329.0	(143,004.9)	128.6
3.2.2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,019.3	74,317.3	(11,298.0)	117.9
3.2.3	Байгууллагын тогтмол зардал	102,525.8	98,382.1	4,143.7	96.0
3.2.4	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын зардал	896,514.0	1,455,360.7	(558,846.7)	162.3
3.2.5	Хангамжийн материалын зардал	8,680.0	23,207.0	(14,527.0)	267.4
3.2.6	Эд хогшил материалын зардал	13,479.9	6,775.9	6,704.0	50.3
3.2.7	Томилолт, зочны зардал, сургалт	79,200.0	257,861.2	(178,661.2)	325.6
4	Элэгдлийн зардал	52,866.0	47,782.0	5,084.0	90.4
<b>5</b>	<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>6,805.0</b>	<b>89,516.3</b>	<b>(82,711.4)</b>	<b>1,315.5</b>
<b>6</b>	<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>6,124.5</b>	<b>80,564.7</b>	<b>(74,440.3)</b>	<b>1,315.5</b>
<b>7</b>	<b>Төсвийн төлбөр</b>	<b>180,089.4</b>	<b>198,492.4</b>	<b>(18,403.0)</b>	<b>110.2</b>
7.1	Аж ахуй нэгжийн орлогын татвар	680.5	8,951.6	(8,271.1)	1,315.5
7.2	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл	133,984.3	136,581.1	(2,596.8)	101.9
7.3	Хувь хүний орлогын албан татвар	45,424.7	52,959.7	(7,535.1)	116.6
7.4	Төрийн өмчийн ногдол ашиг	30,652.2	4,160.0	26,492.2	13.6
7.5	Ажиллагсдын тоо	22	14	8.0	63.6
7.6	Цалингийн сан	500,324.1	643,329.0	(143,004.9)	128.6
7.7	Нэг ажилтны сарын дундаж цалин	1,895.2	3,829.3	1,934.1	202.0
7.8	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал	1.0	1.0	0.0	100.0
7.9	Хөрөнгө оруулалт	9,479.8	3,960.0	5,519.8	41.8
8	Нийт авлага		71,346.7	(71,346.7)	
9	Нийт өглөг		13,195.1	(13,195.1)	
9.1	Үүнээс: Богино хугацаат өр төлбөрт		13,195.1	(13,195.1)	
10	Эздийн өмч		311,851.6	(311,851.6)	
11	Нийт хөрөнгө		736,647.2	(736,647.2)	

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 201.2 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 201.2 сая төгрөгийн алдааг залруулсан.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ААНОАТ-ыг 125.2 сая төгрөгөөр дутуу тайлагнасан	1	125,218.0			1	125,218.0	1	125,218.0				
Худалдан авсан 76.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд зардалд бүртгэсэн.	1	75,997.8			1	75,997.8	1	75,997.8				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>201,216.6</b>			<b>2</b>	<b>201,216.6</b>	<b>2</b>	<b>201,216.6</b>				

Аудитаар нийт 970.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 970.2 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд худалдан авсан 252 харилцагчийн 301.8 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний и баримт цахим системд бүртгэгдээгүй.	1	301,765.9					1	301,765.9				
Тус ТӨААТҮГ нь Байгаль орчин судалгаа шинжилгээний төв УТҮГ зарцуулсан 618.4 сая төгрөгийн зардлыг санхүүгийн тайландаа бүртгэж тайлагнасан байна.	1	618,447.1					1	618,447.1				
Компанийн хөрөнгө оруулалтын 2023 оны төлөвлөгөөнд санхүүгийн програмыг 0.4 сая төгрөгөөр худалдан авахаар батлагдсан боловч төсвийг 3.4 сая төгрөгөөр хэтрүүлэн худалдан авалт хийсэн.	1	3,390.0					1	3,390.0				
Тайланд оны эцэст өр төлбөр дансанд татварын 5.0 сая төгрөг, НДШ-ийн 11.1 сая төгрөг, харилцагчид төлөх 13.2 сая төгрөг, нийт 29.3 сая төгрөг, бусад авлага 17.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан.	1	46,628.2					1	46,628.2				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>970,231.2</b>					<b>4</b>	<b>970,231.2</b>				

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 2 зөрчил илэрснээс 1 төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага хүргүүлсэн.

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

*/мянган төгрөгөөр/*

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Албан шаардлага		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулах мэдээллээс 6 мэдээллийн хугацааг хоцроож байршуулсан байна.	1		1					
<b>Дүн</b>	<b>1</b>		<b>1</b>					
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Өмнөх аудитаар өгсөн “Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэж, ажлын гүйцэтгэлийг хүлээн авах”, “Ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т хүргүүлэх” 2 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд ирүүлээгүй байна.	1				1	1		
<b>Дүн</b>	<b>1</b>				<b>1</b>	<b>1</b>		
<b>Нийт дүн</b>	<b>2</b>		<b>1</b>		<b>1</b>	<b>1</b>		